



МОНГОЛ УЛС  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ  
ХОРООНЫ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 4/05

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр, томилолтоор ажиллах удирдамж,  
сургалтын хуваарь, төсөв батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны мэдээллийн санд бүртгэгдсэн ажилтнуудад зориулсан гэрчилгээ олгох сургалтыг 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс 4 дүгээр сарын 17-ны өдрүүдэд 21 аймагт зохион байгуулсугай.

2. Сургалт зохион байгуулах хуваарь, орон нутагт ажиллах ажилтнуудын нэрсийг 1 дүгээр хавсралтаар, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар, томилолтын удирдамжийг 3 дугаар хавсралтаар, төсвийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтыг батлагдсан хөтөлбөр, удирдамж, хуваарийн дагуу цаг хугацаанд нь чанартай зохион байгуулахыг Ажлын албаны дарга /Д.Баяндүүрэн/, Мэдээлийн технологийн төвийн захирал /Ж.Эрдэнэбат/ нарт тус тус үүрэг болгосугай.


4. Сургалттай холбоотой зардлыг зохих журмын дагуу тооцон сонгуулийн зардлаас санхүүжүүлэхийг Ажлын албаны дарга /Д.Баяндүүрэн/-д, томилолтоор ажилласан тухай тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны дотор Хорооны хуралдаанд танилцуулахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН



000026

Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын  
2016 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн  
*105* дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**БАЙНГЫН БУС АЖИЛЛАГААТАЙ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГАД  
АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН СУРГАЛТЫН ХУВААРЬ**

№	Аймгийн нэр	Ажиллах хүмүүсийн нэрс	Явах хугацаа	Ирэх хугацаа	Ажиллах хоног
1	Төв	1, 2, 3, 4 дүгээр баг	2016.3.28	2016.3.30	2 хоног
2	Хэнтий Дорнод Сүхбаатар	Д.Бат-Эрдэнэ ахлагчтай 1 дүгээр баг	2016.4.3	2016.4.10	7 хоног
3	Архангай Өвөрхангай Баянхонгор	Т.Гүенбаатар ахлагчтай 2 дугаар баг	2016.4.3	2016.4.10	7 хоног
4	Дархан-Уул Сэлэнгэ Орхон Булган Хөвсгөл	Б.Оюумаа ахлагчтай 4 дүгээр баг	2016.4.3	2016.4.12	9 хоног
5	Дундговь Өмнөговь	Б.Нямсүрэн ахлагчтай 3 дугаар баг	2016.4.3	2016.4.8	5 хоног
6	Завхан Говь-Алтай	Т.Гүенбаатар ахлагчтай 2 дугаар баг	2016.4.11	2016.4.16	5 хоног
7	Баян-Өлгий	Б.Нямсүрэн ахлагчтай 3 дугаар баг	2016.4.12	2016.4.16	4 хоног
8	Увс Ховд	Д.Бат-Эрдэнэ ахлагчтай 1 дүгээр баг	2016.4.10	2016.4.15	5 хоног
9	Говьсүмбэр Дорноговь	Б.Оюумаа ахлагчтай 4 дүгээр баг	2016.4.13	2016.4.17	4 хоног

Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын  
2016 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн  
105 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**БАЙНГЫН БУС АЖИЛЛАГААТАЙ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГАД  
АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**Нэг. Хөтөлбөрийн зорилго**

1.1. Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн ажилтны мэдээллийн санд бүртгэгдсэн ажилтан, албан тушаалтанд Сонгуулийн тухай хууль тогтоомжийн талаар сургалт явуулж, гэрчилгээ олгоход энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

**Хоёр. Нийтлэг үндэслэл**

2.1. Сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж явуулах байнгын бус ажиллагаатай аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны гишүүд болон сонгуулийн хэсгийн санал авах байрны ахлах зохион байгуулагч болон бусад зохион байгуулагчдыг сонгуулийн боловсон хүчний мэдээллийн сангаас томилох, Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт зааснаар сонгуулийн ажилтны мэдээллийн санд орсон ажилтан, албан тушаалтанд сонгуулийн хууль тогтоомжийн талаар танхимийн сургалт явуулж, гэрчилгээ олгох ажил хийгдэнэ. Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнууд нь зөвхөн сонгууль товлон зарласнаас хойш сонгогчийн санал авах ажиллагаагаа дуусталх хугацаагаар буюу богино хугацаанд үйл ажиллагаагаа явуулдаг, иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хангахад ихээхэн үүрэгтэй оролцдог тул сонгуулийн хороодын ажилтнуудын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах төрийн захирагааны болон үйлчилгээний албан хаагчид нь үйл ажиллагаагаа зөвхөн хууль тогтоомжийн хүрээнд, улс төрөөс ангид явуулж, ёс зүйтэй, харилцааны өндөр соёлтой байх шаардлагатай. Эдгээр нөхцөл, шаардлагад үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод болон санал авах байранд ажиллах ажилтнуудад сонгуулийн тухай хууль тогтоомжийн талаар явуулах сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

2.2. Шаардлагатай гэж үзвэл хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

**Гурав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

3.1. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалт, нэгдсэн удирдлагаар хангах ажлыг Сонгуулийн Ерөнхий Хороо хариуцана. Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнуудад зохион байгуулах сургалтыг төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг зорилт бүхий төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлж болно. Сонгуулийн ажилтны мэдээллийн сан бүрдүүлэх, сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнуудад сургалт зохион байгуулах үйл ажиллагаа, уг ажиллагаанд оролцох төрийн бус

байгууллагуудыг бүртгэх, сургагч багш нарыг бэлтгэх, сургалтад хамрагдсан ажилтнуудад гэрчилгээ олгох зэрэг харилцааг Сонгуулийн Ерөнхий Хорооны 2016 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 05 тоот тогтоолоор батлагдсан "Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтны мэдээллийн санг бурдүүлэх, сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам"-аар зохицуулна.

3.2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, түүнд хяналт тавих, аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн сонгуулийн хороод, сургалт зохион байгуулахад оролцсон төрийн бус байгууллагуудаас хэрэгжилтийн явцын талаар болон үйл ажиллагааны тайлан гаргуулан авах үргийг Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын алба, Мэдээллийн технологийн төвтэй хамтран хэрэгжүүлнэ.

3.3. Сонгуулийн төв байгууллагын удирдлага нь сонгуулийн ажилтны мэдээллийн санд орсон ажилтнуудыг сургах, гэрчилгээ олгох ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нөхцөлөөр хангана.

#### **Дөрөв. Сургалтын хөтөлбөр**

4.1. Сургалтын хөтөлбөр нь дараах сэдвүүдийг багтаасан байна.

№	Агуулга	Дэд сэдвүүд	Хугацаа
1	Сонгуулийн тухай хуулийн ерөнхий танилцуулга	2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан Сонгуулийн тухай хуулийн онцлог, шинэлэг заалтуудын талаарх танилцуулга	30 минут
2	Сонгуулийн байгууллага, ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим	Сонгуулийн хороод байгуулах, түүний удирдлага, ажлын зохион байгуулалт	20 минут
		Санал авах байрны ажлын зохион байгуулалт	
		Сонгуулийн хороодын үйл ажиллагааны дотоод журам, хуралдааны дэг, ёс зүйн дүрэм	
		Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтны эрх, үүрэг, хариуцлага	
		Авила, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	
3	Сонгогчдын нэрийн жагсаалт, сонгогчийн болон иргэний шилжилт хөдөлгөөн	Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хургуулэх	20 минут
		Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх	
		Сонгогчийн шилжилт	
		Иргэний шилжилт хөдөлгөөн	
4	Сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчдийн бүртгэл	УИХ болон орон нутгийн сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх, бурдүүлэх баримт бичиг Аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр	20 минут

		дэвшигчдийг бүртгэх үйл ажиллагаа, бурдүүлэх баримт бичиг	
5	Сонгуулийн сурталчилгаа	Сонгуулийн сурталчилгаа, мөрийн хөтөлбөр	20 минут
		Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд, тэдгээрийн бүртгэл хөтлөх, үнэмлэх олгох	
		Сонгуулийн сурталчилгааны төрөл Хууль бус сурталчилгааг хориглох, зэрчлийн талаар мэдээлэх	
6	Сонгогчдын санал авах ажиллагаа	Санал авах байр, хугацааг сонгогчдод мэдээлэх	40 минут
		Санал авах байр бэлтгэх, сонгогчийн санал авах үйл ажиллагааг зохион байгуулах	
		Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгааар санал авах ажиллагаа	
		Сонгогч санал авах байранд санал өгөх	
		Сонгуулийн ажиглалт, мониторинг, ажиглагчийн бүртгэл	
7	Сонгуулийн зардлын дансны тайлан гаргах, анхан шатны баримт бурдүүлэлт	Сонгууль зохион байгуулах зардал, туунийг тайлгахаа, анхан шатны баримт бурдүүлэх	15 минут
		Нам, эвслийн болон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хүлээн авах, холбогдох байгууллагад хүргүүлэх	
		Сонгуулийн зардлын тайлангийн хяналт ба нээлттэй, ил тод байдал	
8	Сонгуулийн дун ,мэдээ, судалгаа тайлан гаргах, нэгтгэх, мэдээлэх үйл ажиллагаа	Санал тооюу ажиллагааг зохион байгуулах	40 минут
		Техникийн тооллого зохион байгуулах, санал болон саналын хуудсыг хүчингүйд тооцох	
		Санал хураалтын дун, сонгуулийн холбогдолтой бичиг баримтыг хүргүүлэх, хадгалах, архивт хүлээлгэн өгөх	
		Дахин болон нэмэлт санал хураалт	
9	Хууль тогтоомж зэрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага, өргөдөл гомдол, маргаан шийдвэрлэх	Сонгуулийн тухай хууль, Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж зэрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага	15 минут
		Өргөдөл, нэхэмжлэл гаргах	
		Өргөдөл шийдвэрлэх	
		Нэхэмжлэл шийдвэрлэх	
		Зөрчил шийдвэрлэх үйл ажиллагаа	
10	Сонгуулийн автоматжуулсан системийн үйл ажиллагаа	Санал авах, тооюу төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангах – МТТ	20 минут
<b>Сургалтын нийт үргэлжлэх хугацаа</b>			<b>4.00 цаг</b>

**Тав. Сургалтын хөтөлбөрийн санхүүжилт**

5.1. Хөтөлбөрийн санхүүжилтийг улсын төсвөөс хуваарилсан сонгуулийн зардлаас гүйцэтгэнэ.

5.2. Сургалтад шаардагдах зардлыг тогтоосон норм, нормативын хүрээнд төсөвлөн батлуулж, зарцуулалтыг тайлагнан, санхүүгийн баримтын бүрдлийг ханган ажиллана.

**Зургаа. Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээ, хугацаа, үр дүн**

6.1. Сургалтыг тухайн аймаг, дүүрэгт нь хийх бөгөөд бүсчилсэн байдлаар хийж гүйцэтгэж болно.

6.2. Хөтөлбөрийн эхний хэсгийг 2016 оны 3 дугаар сарын сүүлийн 10 хоногоос эхлүүлэн 4 дүгээр сарын 2 дугаар арав хоногт багтаан сонгуулийн ажилтны мэдээллийн санд бүртгэгдсэн ажилтнуудыг хамруулан хэрэгжүүлж, сургалтанд хамрагдсан ажилтнуудад гэрчилгээ олгоно.

6.3. Дахин болон нөхөн сонгууль, дараагийн ээлжит сонгуулийн үеэр сонгуулийн хороодод ажиллах боловсон хүчиний нөөцөөс хамааран шаардлагатай тохиолдолд сургалт явуулж болох бөгөөд сургалт явуулах газар, хамрагдах хүрээ, хугацааг тухай бүрт нь тогтооно.

6.4. Хөтөлбөр хэрэгжсэнээр байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнууд Сонгуулийн тухай хууль, сонгуулийн зохион байгуулалтын ўйл ажиллагааны талаар цэгцтэй мэдлэг, мэдээллтэй болох бөгөөд гэрчилгээ бүхий ажилтнуудаас аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүн болон сонгуулийн хэсгийн санал авах байрны ахлах зохион байгуулагч болон бусад зохион байгуулагчдыг томилон ажиллуулна.

---оОо---

Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын  
2016 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн  
10 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ АЖЛЫН АЛБА, МЭДЭЭЛЛИЙН  
ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН АЖИЛТНУУДЫН ОРОН НУТАГТ СУРГАЛТ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ**

**Нэг. Нийтлэг үндэслэл, зорилго**

1.1. Сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Сонгуулийн ажилтны мэдээллийн санд орсон ажилтан, албан тушаалтанд сонгуулийн хууль тогтоомжийн талаар сургалт явуулж, гэрчилгээ олгоно” гэж заасны дагуу Сонгуулийн тухай хууль, энэхүү хуультай нийцүүлэн батлан гаргасан журам, заавар, загвар, маягтын талаар тайлбарлан таниулах, гэрчилгээ олгоход энэхүү сургалтын зорилго оршино.

**Хоёр. Хамрах хүрээ, чиглэл**

2.1. Сургалтыг Сонгуулийн Ерөнхий Хорооны Ажлын алба болон Хорооны дэргэдэх Мэдээллийн Технологийн төвийн ажилтнууд хамтран зохион байгуулна.

2.2. Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнуудад зориулсан сургалтыг 21 аймаг, 9 дүүрэгт хийх бөгөөд батлагдсан хуваарийн дагуу явагдана.

2.3. Сонгуулийн ажилтны мэдээллийн санд бүртгүүлэхээр ирүүлсэн төрийн албан хаагчдын талаарх мэдээллийг нягтлан шалгана. Ийнхүү нягтлан шалгахдаа иргэний үнэмлэх, төрийн албанд томилогдсон шийдвэрийн хуулбартай тулгана.

**Гурав. Сургалт зохион байгуулах хугацаа, бүрэлдэхүүн**

3.1. Сургалтыг 2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс 2016 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийг дуусталх хугацаанд багтаан явуулна.

3.2. Сургалтыг 4 баг хариуцан явуулах бөгөөд багийн бүрэлдэхүүнд ажлын ачаалал, тухайн үеийн нөхцөл байдал, шаардлагаас хамааран Ажлын алба, Мэдээллийн технологийн төвөөс ажилтан нэмж томилж болно.

**Дөрөв. Сонгуулийн автоматжуулсан системийг хэрэгжүүлэхтэй  
холбоотойгоор шалган турших ажлын жагсаалт**

4.1. Аймагт хадгалагдаж буй саналын хайрцагны хадгалалт, хамгаалалт болон эвдрэл гэмтлийг шалган тоолж, тэмдэглэл хөтөлнө.

4.2. Саналын хайрцагт санал тоолох төхөөрөмжийг угсарч шалгана.

4.3. Тухайн аймагт ажиллах Мэдээллийн технологийн багт ажиллах хүмүүсийн судалгааг шинэчлэн гаргана.

4.4. Мэдээллийн технологийн даамлын судалгааг гаргана.

4.5. Аймгийн сонгуулийн хороонд ашиглах компьютерыг бэлтгүүлэх, Төрийн сангийн сүлжээтэй холбогдож буй эсэхэд хяналт тавьж, СЕХ-ны төв сервер рүү хандалт хийж шалгана.

4.6. Санал авах байрны байршил, дүн дамжуулах сүлжээний талаар судалгаа гаргуулж авна.

4.7. Санал авах байрны координатыг хэрхэн авах талаар зааварчилгаа өгч санал авах байрны координатын судалгааг бүрдүүлнэ.

#### **Тав. Ажил тайллагнах**

5.1. Удирдамжийн дагуу томилолтоор ажилласан тухай тайланг 4 дүгээр сарын 25-ны дотор гаргаж Хороонд танилцуулна.

5.2. Сонгуулийн ажилтны мэдээллийн сангийн мэдээллийг нягтлан шалгаж, сургалтанд хамрагдан, гэрчилгээ авсан ажилтнуудын бүртгэлийг тайланд хавсаргасан байна.

5.3. Аймаг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дутуу ирүүлсэн, өмнөх сонгуулиудаар ашиглагдаж байсан тойргийн хороо, аймгийн сонгуулийн хороо, салбар хороо, сум, дүүргийн сонгуулийн хорооны болон хэсгийн хорооны тэмдгүүдийг авчирч Захиргаа, санхүүгийн хэлтсийн хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө. Дээрх тэмдгүүдийг тухайн аймаг ирүүлэх боломжгүй /гээгдүүлсэн, эвдэрсэн/ тохиолдолд энэ тухай тайлбарыг албан бичгээр гаргуулан авна.

---оо---

Сонгуулийн Ерөнхий Хорооны даргын  
2016 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн  
100 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт

**БАЙНГЫН БУС АЖИЛЛАГААТАЙ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГАД  
АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ БАГИЙН  
ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ ТОМИЛОЛТЫН ТӨСӨВ**

Төв аймаг: 2016.03.28-30

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Автомашины зардал /УБ-ТӨ-УБ/	100	2	15	600.0	60,000.0	50,000
2	Томилолтын мөнгө		2	15	29,000.0	870,000.0	870,000
	ДҮН		2	15	x	930,000.0	930,000

Хэнтий-Дорнод-Сүхбаатар аймаг: 2016.04.03-10

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Автомашины зардал /УБ-ХЭ-ДО-СБ-УБ/	1520	7	5	600.0	912,000.0	
2	Томилолтын мөнгө		7	5	29,000.0	1,015,000.0	
	ДҮН		7	5	x	1,927,000.0	1,927,000

Архангай-Өвөрхангай-Баянхонгор аймаг: 2016.04.03-10

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Автомашины зардал /УБ-АР-ӨВ-БХ-УБ/	1885	7	5	600.0	1,131,000.0	
2	Томилолтын мөнгө		7	5	29,000.0	1,015,000.0	
	ДҮН		7	5	x	2,146,000.0	2,146,000

Дархан-Уул-Сэлэнгэ-Орхон-Булган-Хөвсгөл аймаг: 2016.04.03-12

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Автомашины зардал /УБ-ДА-СЭ-ОР-БУ-ХӨ-УБ/	1900	9	4	600.0	1,140,000.0	
2	Томилолтын мөнгө		3	4	35,500.0	426,000.0	
	ДҮН		6	4	29,000.0	696,000.0	
			9	4	x	2,262,000.0	2,262,000

Дундговь-Өмнөговь аймаг: 2016.04.03-08

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Автомашины зардал /УБ-	1190	5	5	500.0	595,000.0	
2	Томилолтын мөнгө		5	5	29,000.0	725,000.0	
	ДҮН		5	5	x	1,320,000.0	1,320,000

Увс-Ховд аймаг: 2016.04.10-15

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Онгоц /УБ-УВ-ХО-УБ/		5	3	645,000.0	1,935,000.0	1'845'300F
2	Томилолтын мөнгө		5	3	29,000.0	435,000.0	
	ДҮН		5	3	x	2,370,000.0	

Завхан-Говь-Алтай аймаг: 2016.04.11-16

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Онгоц /УБ-ГА, ЗА-УБ/		5	3	650,000.0	1,950,000.0	1'867'200F
2	Автомашины зардал /ГА-ЗА/	400	5	3	600.0	240,000.0	
3	Томилолтын мөнгө		5	3	29,000.0	435,000.0	
	ДҮН		5	3	x	2,625,000.0	

Баян-Өлгий аймаг: 2016.04.12-16

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Онгоц /УБ-БӨ-УБ/		4	3	450,000.0	1,350,000.0	1'277'100F
2	Томилолтын мөнгө		4	3	29,000.0	348,000.0	
	ДҮН		4	3	x	1,698,000.0	

Говьсүмбэр-Дорноговь аймаг: 2016.04.13-17

№	Үзүүлэлт	км	хоног	Хүний тоо	нэг бүрийн үнэ	Бүгд	Гүйцэтгэл
1	Автомашины зардал /УБ-ГС-ДГ-УБ/	930	4	5	500.0	465,000.0	
2	Томилолтын мөнгө		4	5	29,000.0	580,000.0	
	ДҮН		4	5	x	1,045,000.0	03.11
1	Онгоцны тийз					5,235,000.0	4'983'800
2	Автомашины зардал					4,543,000.0	
3	Томилолтын мөнгө					6,545,000.0	
	НИЙТ ДҮН		48	48	x	16,323,000.0	